Улсын Их Хурлын Тамгын газар
Судалгааны төв

СТ-11/423

ЗАРИМ УЛС ОРНУУД ДАХЬ СОНГУУЛИЙН ХОЛИМОГ ТОГТОЛЦООНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

(Лавлагаа мэдээлэл)

Захиалагч: УИХ-ын Тамгын газрын
Нарийн бичгийн дарга
С. **Магнайсүрэн**

Гүйцэтгэсэн: **Ц.Товуусүрэн**
Р.Хатанбаатар
А.Пагма
Ц.Болормаа

Улаанбаатар хот
2011 он

Санал

1. Улсын Их Хурлын гишүүдийг сонгуулийн холимог системээр сонгоно.

- Сонгуулийн 26 тойргоос 48 гишүүнийг мажоритар системээр сонгоно. Нэг мандаттай тойрогт саналын босго 50%+1, хоёр мандаттай тойрогт 33,33%+1, гурван мандаттай тойрогт 25%+1 байна. Энэхүү босгын болзлыг сонгуулийн эхний санал хураалтаар тухайн тойрог дахь мандатын тооноос цөөн нэр дэвшигч хангасан тохиолдолд хоёр дахь шатны санал хураалт явуулна.

- Сонгуулийн улсын хэмжээний 1 тойргоос 28 гишүүнийг пропорциональ системээр сонгоно. Пропорциональ сонгуульд зориулан улс төрийн нам, эвслүүд 76-аас илүүгүй нэр бүхий нэр дэвшигчдийн жагсаалт гаргаж сонгуулийн Ерөнхий хороонд санал хураах өдрөөс ... хоногийн өмнө хүргүүлнэ. Уг жагсаалтад нэр дэвшигчдийн нэрийг хатуу тогтсон дараалалд оруулсан байх ба СЕХ жагсаалтыг улс орон даяар зарлана.

2. Сонгогч хоёр санал гаргана.

- Мажоритар сонгуулийн тойрогт саналын хуудсанд байгаа аль нэг нэр дэвшигчийн нэрийн өмнөх дугаарыг дугуйлж саналаа гаргана. (*өөр нэг хувилбар: саналын хуудсанд байгаа тухайн тойрог дахь мандатын тоотой тэнцүү тооны нэр дэвшигчийн нэрийн өмнөх дугаарыг дугуйлж саналаа гаргана.)*

- Сонгогч хоёр дахь саналаа пропорциональ сонгуулийн тойрогт дэвшүүлсэн намуудын нэрсийн жагсаалтын аль нэгийн өмнөх дугаарыг дугуйлж гаргана. (*хоёр дахь хувилбар: Сонгогч саналын хуудсанд хавсаргасан намуудын нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтад байгаа аль нэг нэр дэвшигчийн нэрийн өмнөх дугаарыг дугуйлж саналаа гаргана).* Ийнхүү гаргасан саналыг тухайн улс төрийн нам, эвсэлд өгсөн саналд тооцно.

3. Пропорциональ сонгуулийн тойрогт нийт хүчинтэй саналын 4% -иас доошгүйг авсан нам, эвсэлд авсан саналтай пропорциональ тооны суудал хуваарилна. (*28 суудлын нэг нь 3,57 хувьтай тэнцэж байна.*)

4. Мажоритар сонгуулийн тойрогт сонгогдсон нэр дэвшигчийн нэрийг намаас гаргасан нэр дэвшигчдийн жагсаалтаас хасна. Ийнхүү хассаны дараа нам эвслийн нэр дэвшигчдийн жагсаалтын эхнээс дарааллын дагуу тухайн нам, эвсэлд пропорциональ тойрогт оногдсон суудлын тоотой тэнцүү нэр дэвшигчдийг гишүүнээр сонгогдсонд тооцно.

Нэг. Шинэ Зеландын сонгуулийн хуулийн зарим

зохицуулалт

1. Сонгуулийн систем

Шинэ Зеланд улс парламентын сонгуулийг ММР (*mixed member proportional*)[1] системээр явуулж байна. Энэ нь 2 шатлал бүхий сонгуулийн холимог систем юм. Доот шатаар орон нутгийн төлөөлөгчийг тогтоодог бол дээд шатаар Танхимын пропорциональт байдлыг /*аль нам нь хичнээн хувийг бүрдүүлж байгааг*/ тогтоодог байна.

ММР нь Парламентын 120 суудлын 70-ыг нэр дэвшигчийн нэрийн өмнөх дугуйг бөглөх, үлдсэн 50-ийг нь намын жагсаалтаас сонгон өмнөх дугуйг бөглөнө.

2. Сонгогч санал гаргах

Шинэ Зеландад сонгогч хоёр саналын эрхтэй. Өөрөөр хэлбэл, сонгогчид 2 санал гаргана. "намын төлөөх санал" болон "нэр дэвшигчийн төлөөх санал".

- Гол санал *(main vote)* нь "намын төлөөх санал" *(party vote)* юм. Энэ саналаар танхимын пропорциональт байдлыг /*аль нам нь хичнээн хувийг бүрдүүлж байгааг*/ тодруулах буюу, энэ нь сонгуулийн системийн дээд шатлал байна. Төлөөлөгчдийн танхимы 50 гишүүдийг үндэсний хэмжээний намын жагсаалтаас сонгох ба намын төлөө өгсөн бүх саналыг нам бүрээр хуваарилж гаргана. Нам нь намын төлөөх бүх саналаас хамгийн багадаа 5 хувийн санал авах ёстой, эсвэл Төлөөлөгчдийн танхимын суудлын жагсаалтыг хуваарилахад electorate seat авсанаар ялна.

- Нөгөө санал нь "нэр дэвшигчийн төлөөх санал" *(electorate vote)* бөгөөд энэ нь доод шат юм. Энэ саналаар танхим доторх орон нутгийн төлөөлөгчийг тодруулах бөгөөд энэ нь пропорциональт байдлыг /*аль тогтолцоо нь хичнээн хувийг бүрдүүлж байгааг*/ өөрчлөхгүй. Нэр дэвшигчийн төлөөх санал нь энгийн олонхийн системээр ажиллах ба, тойрогтоо хамгийн өндөр санал авсан нэр дэвшигч сонгогдоно.

Энгийн мажоритар саналаар 63 гишүүнийг Ерөнхий сонгуулийн тойргоос* сонгох бол, 7 гишүүнийг Маоригийн сонгуулийн тойргоос сонгоно.

Шинэ Зеландын сонгуулийн хуулинд сонгогч санал өгөх аргачлалыг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

168-р зүйл . Санал өгөх аргачлал [2]

168.(1). Сонгогч саналын хуудсыг хүлээн авч:

a) Дотор байрлах зориулалтын тасалгаа руу шууд орж,
b) Ганцаарчилан болон нууцаар санал өгнө:
    i. Намын төлөөх саналыг тэмдэглэхдээ, сонгохыг хүсч буй намынхаа нэрний өмнөх дугуй дээр зөв гэсэн тэмдэглэгээ тавьж сонгох намаа тэмдэглэнэ,

[1] http://en.wikipedia.org/wiki/Electoral_system_of_New_Zealand
[2] Сонгуулийн хууль. 1993 он. №87, 6 дугаар бүлэг, 168 дугаар зүйл.
* Сонгуулийн ерөнхий тойрог гэдэг нь Маоригийн сонгуулийн тойргоос бусад тойргийг ойлгоно.

ii. Нэр дэвшигчийн төлөөх саналыг тэмдэглэхдээ, тухайн тойрогт нэр дэвшигчдийн хэнд нь өгөхийг хүсч буй тухайн нэр дэвшигчийн нэрний өмнөх дугуй дээр зөв гэсэн тэмдэглэгээ хийнэ.

168.(2). Саналын хуудсанд зөвхөн намын төлөөх санал, эсвэл зөвхөн нэр дэвшигчийн төлөөх санал байх ба энэ зүйлийн 3 дахь заалтыг 1 дэх заалтын оронд дагаж мөрдөнө.

168.(5). Сонгогч бүр зориулалтын тасалгааг орхин гарахаас өмнө, доторхи агуулгыг нь үзэх боломжгүйгээр саналын хуудсыг нугалан, нугалаастай нь саналын хайрцаганд хийнэ.

3. Санал тоолох, суудал хуваарилах

Шинэ Зеландын сонгуулийн хуулийн 6 дугаар бүлгийн “Саналын урьдчилсан тооллого”, “Албан ёсны саналын тооллого болон үр дүнг зарлах”, “Дахин тоолох” гэсэн дэд бүлгүүдээр санал тоолох харилцааг, мөн хуулийн 6-р бүлгийн “Суудлын жагсаалт” гэсэн дэд бүлгээр суудал хуваарилах харилцааг тус тус зохицуулсан байна.

Хуулийн “Саналын урьдчилсан тооллого”, “Албан ёсны саналын тооллого болон үр дүнг зарлах”, “Дахин тоолох” гэсэн дэд бүлгүүдээр санал тоолох процесс, тооллогын комисс түүнийг батлах журам, саналын хуудсыг зөв тоолж буй эсэхэд хяналт тавих ажиглагчийн үйл ажиллагааг нэг бүрчлэн зохицуулсан байна. Түүнчлэн санал дахин тоолох үндэслэл, журам, тооллогын комиссын талаар нэг бүрчлэн зохицуулсан байна. Тухайлбал, дахин тооллогыг зөв явуулж буй эсэхийг хянах болон суудлын жагсаалтын хуваарилах талаар дараах байдлаар зохицуулсан байна. Үүнд:

183-р зүйл: Дахин тооллогыг нягтлах болон суудлын жагсаалтыг хуваарилах

1) Аливаа сонгуулийн тойрогт нэр дэвшигч энэ хуулийн 180-р зүйлийн нэгт заасны дагуу сонгуулийн тойрог дахь саналын хуудсыг дахин тоолох хүсэлт гаргасан бол нэг болон түүнээс дээш хөндлөнгийн ажиглагч байлцуулахаар томилно.

2) Аливаа улс төрийн нам:

i. Энэ хуулийн 180-р зүйлийн 2-т зааснаар сонгуулийн тойргийн намын төлөөх саналыг дахин тоолуулахаар хүсэлт гаргасан бол,

ii. Энэ хуулийн 181-р зүйлийн 1-т зааснаар сонгуулийн бүх тойргийн намын төлөөх саналыг дахин тоолуулахаар хүсэлт гаргасан бол дахин тооллого хийлгүүлэхээр 1 болон түүнээс дээш хөндлөнгийн ажиглагч томилно.

3) Намын төлөөх саналтай холбоотойгоор саналын хуудасны хэсэгт бүртгэгдсэн улс төрийн аль ч нам 1 ба түүнээс дээш хөндлөнгийн ажиглагч томилж болох ба энэ тухайгаа энэ хуулийн 191-р зүйлээс 193-р зүйлд заасны дагуу Сонгуулийн хорооноос суудал хуваарилах үед танилцуулна.

4) Хөндлөнгийн ажиглагч бүр энэ хуулийн холбогдох заалтад заасан ёсоор батлагдаж, хуулиар зөвшөөрөгдөхөөс өмнө Сонгуулийн комиссар, Сонгуулийн хорооны ажилтан, эвийн шүүгч, эсвэл солисторын өмнө тунхаглал гаргана.

5) Суудлын жагсаалтыг хуваарилах үед улс төрийн нам нь хөндлөнгийн ажиглагчаар нэгээс дээш гишүүнийг томилсон тухай танилцуулах бол улс төрийн намын зөвхөн нэг хөндлөнгийн ажиглагч байх, эсхүл Сонгуулийн хорооны зөвшөөрлийг авсан бол нэгээс дээш ажиглагчийг хэдийд ч томилж болно.

6) Хөндлөнгийн ажиглагчийн талаарх энэхүү заалтыг нэр дэвшигч хэрэгжүүлэхгүй.

7) Тооллогын комиссын гишүүнийг энэхүү заалтын дагуу факсаар томилж болно.

Суудал хэрхэн хуваарилах талаархи хуулийн зохицуулалтыг багцлан үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

- Хэрэв намаас сонгогдсон гишүүдийн тоо нь тухайн намын авсан саналын дагуу тухайн намд олгогдсон тооны эрхэнд хүрэхгүй бол гишүүний тоог гишүүдийн жагсаалт дахь дараагийн гишүүнээр нөхөж гүйцээх буюу үүнийг "tops up" гэж нэрлэнэ. Өөрөөр хэлбэл, пропорциональ системээр санал хураах "намын төлөөх санал" хураалтын үед энэхүү зарчим ашиглагдана.
- Шинэ Зеландийн сонгуулийн системийн дагуу суудал нь эхлээд тойрогт ялсан нэр дэвшигчдийн дунд хуваарилагддаг.
- Түүний дараа намууд нь "намын төлөөх санал"-ын хувьтай ойролцоо хувиар парламентад суудал эзэлдэг. Хэрэв нам нь сонгуулийн тойрогт "намын төлөөх санал"-ын дагуу авсан суудлаас илүү суудал авсан бол тухайн илүү суудлаа хадгалж болох бөгөөд үүнийг нь "overhang seats"[3] гэж нэрлэнэ.

Хоёр. ХБНГУ-ын сонгуулийн хуулийн зарим зохицуулалт

ХБНГУ-ын Үндсэн хуулийн 38 дугаар зүйлд "Германы Бундестагын депутатуудыг бүх нийтийн, шууд, чөлөөт, тэгш, нууц сонгуулийн үндсэн дээр сонгоно..." хэмээн холбооны сонгуулийн эрхийн үндсэн зарчмыг хууьчилжээ.

"Сонгуулийн тухай" Холбооны хуульд Германы Бундестагын сонгуулийг холимог системээр явуулахыг хуульчилжээ[4]. Германы Бундестаг нийт 656 депутаттай ба эдгээрээс 328 депутатыг нэг мандаттай сонгуулийн тойргоос, үлдсэн 328 депутатыг улс төрийн намуудын нэрсийн жагсаалтаар сонгодог байна[5].

1. Санал гаргах.

Сонгуулийн энэхүү системийн дагуу сонгогч тус тусдаа, бие даасан, бие биенээсээ харилцан үл хамаарах хоёр саналыг гаргана. Нэгдүгээр санал нь сонгуулийн тойргоос сонгогдож байгаа нэр дэвшигчийн төлөө өгөх бол хоёрдугаар саналыг намын нэрсийн жагсаалтанд байгаа аль нэг намын төлөө өгнө.

Сонгуулийн тойрогт буюу мажоритар хувилбараар сонгогдож байгаа тойрогт аль олон нэгдүгээр санал авсан нэр дэвшигч сонгогдоно.

[3] http://www.ipu.org/parline-e/reports/2233.htm

[4] Федеральный закон о выборах от 7 мая 1956 г. § 1 (2), (Вестник федерального законодательства, I, стр. 383)

[5] Мөн тэнд

Хоёрдугаар саналыг сонгогч 16 Холбооны муж улс тус бүрийн улс төрийн намуудаас гаргасан намын жагсаалтаас аль нэг намыг сонгоно. Энэхүү улс төрийн намаас гаргасан жагсаалтанд бичигдсэн нэр дэвшигчдийн нэрс, хатуу тогтоосон дэс дарааллыг сонгогч өөрчлөх эрхгүй.

2. Саналын дүнг нэгтгэх

Сонгуулийн дараа сонгогчдын өгсөн хоёрдугаар саналын дүнг үндэслэн Холбооны сонгуулийн комисс нь сонгуульд орсон улс төрийн намуудад Германы Бундестагын суудлыг хуваарлах ба энэ нь сонгуулийн дүнд тодорхойлох үүрэг гүйцэтгэдэг.

Саналын хуудас нь дараах агуулгатай байдаг.Үүнд:

1. Сонгуулийн тойргийн хувьд- тухайн тойрогт нэр дэвшиж байгаа нэр дэвшигчийн нэр, хэрэв намаас нэрийг нь дэвшүүлж байгаа бол тухайн намынх нь нэр, хэрэв тусгай тэмдэгтэй бол энэхүү тэмдэг, үгүй бол зохих томъёлсон тэмдэг

2. Намын нэрсийн жагсаалтын хувьд- намын нэр, хэрэв тусгай тэмдэгтэй бол энэхүү тэмдэг, мөн тухайн намын нэрсийн жагсаалтын эхний 5 нэр дэвшигчийн нэр бичигдсэн байна[6].

Гурав. Румын улсын сонгуулийн систем

Парламентын сонгуулийг холимог хэлбэрээр явуулна. Сонгогч зөвхөн нэг нэр дэвшигчийн төлөө санал өгнө.

<u>Мажоритар систем</u>

50 хувиас дээш санал авсан нэр дэвшигч энэ системээр сонгогдоно.

<u>Пропорционал систем</u>

Сонгогдоогүй үлдсэн нэр дэвшигчдийн саналыг улсын хэмжээнд нэгтгэнэ. Ингээд парламентын үлдсэн суудлыг намуудын авсан саналын тоотой нь пропорционалиар нам, эвсэлд хуваарилана.

Сонгуульд дангаараа оролцсон нам сонгогчдын 5 хувиас дээш санал авсан бол суудал хуваарилалтанд оролцоно. Гэхдээ 5 хувийн босгыг даваагүй боловч мажоритариар явагдсан сонгуульд 6-гаас доошгүй суудал авсан намд мөн пропорционалиар суудал хуваарилагдана.

Сонгуульд хоёр нам эвсэн орсон бол пропорционалиар суудал хуваарилах босго 8 хувь, гурван намын эвсэл орсон бол 9 хувь, дөрөв юмуу түүнээс олон нам эвсэн орсон бол 10 хувийн босго тус тус байна.

[6] § 30 Избирательные бюллетени, 2